



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/194

Мандалговь

Удирдах ажилтнуудын шуурхай
цуглаан зохион байгуулах
журам батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн сумд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой, байгууллага, аж ахуй нэгж, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, газар агентлагуудын удирдах ажилтнуудын шуурхай зохион байгуулах журмыг нэгдүгээр, шуурхай цуглаанд оролцох албан тушаалтнуудын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдах ажилтнуудын шуурхай цуглаан зохион байгуулах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/247 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210347